



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 66

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 14 дүгээр зүйлийн 4, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Иргэний хуулийн 111 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 32 дугаар тогтоолын 32.8, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн Капитал банкин дахь нийт 75,407,453.86 (далан таван сая дөрвөн зуун долоон мянга дөрвөн зуун тавин гурван төгрөг наян зургаан мөнгө) төгрөгийн харилцах дансны авлагад тооцон тус банкны эрх хүлээн авагчаас санал болгож хүлээн авахаар тохиролцсон 70,000,000.00 (далан сая) төгрөгийн үнэлгээ бүхий Ландкрузер-200 маркийн автомашиныг тус компанийн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбуу нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Автомашины улсын дугаарыг шилжүүлэн авч, арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх;

2.3. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ



13201095

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2021 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн  
66 дугаар тогтоолын хавсралт



**"ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХӨРӨНГӨД  
БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн /Ашиглалтанд орсон он	Тоо хэмжээ (ш)	Балансын үнэ (төгрөг)
1	Тоёота Ландкрузер-200, 05-00 УБЗ, JTMDU09J4D5068327	2012/2013	1	70,000,000.00
Нийт дүн				70,000,000.00
				(далан сая)